



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/506

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй
болгох тухай

“Автор строй” ХХК-ны аймгийн Засаг даргын тамгын газрын зүүн талд байрлах 1500м² газар нь аймгийн Төрийн архивын газартай давхцаж байгаа мөн тухайн компани газар дээрээ үйл ажиллагаа явуулаагүй тул Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Эзэмшил газраа гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй “Автор строй” ХХК-ны Номгон 1-р багт байрлах 040700181-1 нэгж талбарын дугаар бүхий Бизнес хөгжлийн зориулалттай 1500 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

2.Хүчингүй болсон газрын мэдээллийг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т заасны дагуу улсын бүртгэлд тусгуулж, газар эзэмшигчид мэдэгдэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3.Газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг зэрэг бусад бичиг баримтыг хураалгахыг “Автор строй” ХХК (Ж.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай

5.Энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210169